

**ХИРГИСИЙН ХООЛОЙН ДӨРВӨЛЖИНГИЙН МАЛТЛАГААС
ОЛДСОН ДЭЭВРИЙН ВААР ДЭЭРХ БИЧЭЭС**

А.Очир*
Ц.Баттулга**

Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Өвөр Монголын өөртөө засах орны Соёлын өв болон тус улсын Археологийн хүрээлэнтэй хамтран, 2011 онд Архангай аймгийн Хотонт сумын нутаг Хиргисийн хоолой хэмээх газарт хийсэн археологийн малтлагаар руни бичээс бүхий дээврийн нөмрөг ваар илрүүлсэн билээ¹. Эл бичигт ваар Хиргисийн хоолойн 6-р дөрвөлжингийн малтлагын талбайн XXII хэсгийн 4-р үеийн Р-13 өрөгт, өнгөн хөрснөөс доош 40 см-ээс илэрсэн бөгөөд малтлагын талбайн энэ хэсэгт дээврийн ваарны хагархай ихээр илэрснийг тэмдэглэх нь зүйтэй.

Бичээс бүхий энэхүү нөмрөг ваар гурван хэсэг болж хагарсан байсан болно. Эхний хагархай 4-р үеэс, үлдсэн хоёр хагархай нь 5-р үеэс тус тус илэрчээ. Ваарны хагархайг олдсон дэс дарааллаар нь дугаарласан ажээ.

Уг нөмрөг ваар нь барилга нурахад унаж хагарсан бололтой. Нөмрөг ваарыг үйлдэхдээ нарийн ширхэгтэй шаврыг нягт нарийн шигшүүрээр шигшиж, улмаар сайтар шатаан таар ашиглаж байсны ул мөр болох иржгэр хээ ваарны дотор талд тод үлджээ. Харин гадна талыг нь сайтар гөлийлгөж зассан байна.

Дээврийн ваарны нийт урт нь 31.5 см, өргөн нь 12.7 см, зузаан 2.3 см бөгөөд углуургатай талаасаа бага зэрэг өргөссөн ажээ. Углуургатай буюу дээд талын өргөн нь 12.5 см, доогуураа 13.5 см, углуургын урт 2.5 см болно. Дээд ирмэгээс углуурга руу буусан налуу нь огцом бөгөөд бага зэрэг дотогшоо болохыг тэмдэглэе.

Ваарны нэгдүгээр хагархай 8 см, хоёрдугаар хагархай 10 см, гуравдугаар хугархай 19.8 см урт болно. Нэгдүгээр хагархай хадгалалт дунд зэрэг, харин үлдсэн хоёр хагархай сайн хадгалагджээ. Нөмрөг ваар дээрх бичээс хоёр мөр бөгөөд мөр хоорондын зай ойролцоогоор 0.7 см.

* UNESCO-ын харьяа “Нүүдлийн Соёл Иргэншлийн Хүрээлэн”

** Монгол Улсын Их Сургууль, Гадаад Хэл Соёлын Сургууль

¹ Энэ судалгааны ангид Монголын талаас проф.А.Очир, Б.Анхбаяр, Н.Ганбаатар, Б.Уртнасан, Х.Цэрэндагва нар, Хятадын талаас Чэн Ен Жи, Сун Гоу Дун, Ю Гоу Мин, Саранбилиг нар оролцжээ.

Бичээсийн нэгдүгээр мөр 1-1.5 см дундаж өндөртэй, 14 үсэг тэмдэгтээс бүрдэнэ. Харин хоёрдугаар мөр 15 үсэг тэмдэгтээс бүтэх бөгөөд дундаж өндөр нь 1.5-2 см байна. Мөн хоёрдугаар мөрийн үсэг тэмдэгтийн хоорондох зай ихээс гадна үсгийн хэмжээ нь нэгдүгээр бичээстэй харьцуулахад харьцангуй том ажээ. Энэхүү бичээсийг хоёр хувилбараар унших боломжтой юм.

Нэгдүгээр хувилбар:

Бичээсийн эхийн сийрүүлэг:

- ᠳᠤᠶᠢᠨᠲᠤ ᠶᠢᠯᠠᠵᠢ ᠶᠢᠲᠢᠨᠴᠢ ᠶ
- ᠪᠢᠵᠢ ᠶᠢᠭᠢᠷᠮᠢᠬᠢᠪᠢᠳᠢᠮ

Үсгийн галиг

- Y Wnt Y iL Q a y i t i nč Y
- biz yig r m i k a bit d m

Нэгдүгээр хувилбар:

Үгийн галиг

- yont yilqa yitinč ay
- biz yigirmikā bitdim

Үгчилсэн орчуулга

- Морин жилд долоодугаар сар
- бид хоринд бичив би

Утгачлан буулгавал:

“Морин жилийн долоодугаар сарын хоринд бид, бичив би” болно.

Хоёрдугаар хувилбар:

Үгийн галиг

- yont yilqa yitinč ay
- ābiz yigirmikā bitdim

Үгчилсэн орчуулга

- Морин жилд долоодугаар сар
- Эбиз (Абиз) хоринд бичив би

Утгачлан буулгавал:

“Морин жилийн долоодугаар сарын хоринд Эбиз(Абиз) бичив би” болмуй.

Монгол нутгаас өмнө нь Түрэгийн үед холбогдох, Ту Ньюкукийн тахилын цогцолборт сүмийн шаваасны бичээс², Цэцүүхийн тахилын сүмийн дээврийн ваарны хагархай дээрх бичээс³

² Н.Сэр-Оджав, Шинэ олдсон түүрэг бичээсийн тухай, - Studia Archaeologica, Tom.1, fasc.7, Улаанбаатар, 1960, 3-4 дүгээр тал; С.Харжаубай, Эртний гурван бичээс, -Археологийн судлал, Том.VII, fasc.10-18, Улаанбаатар, 1979, 33 дугаар тал; Л.Болд, Тонькукийн II бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 107 дугаар тал; Ц.Баттулга, Монголын руни бичгийн бага дурсгалууд, Тэргүүн дэвтэр, Corpus Scriptorum, Tom.I, Улаанбаатар, 2005, 173-177 дугаар тал.

³ А.Очир, Д.Эрдэнэбаатар, Цэцүүхийн бичээс, -Археологийн судлал, Том.XIX, fasc.10, Улаанбаатар, 1999, 88-90 дүгээр тал.

зэрэг тахил, тахилгын сүмийн холбогдолт бичгийн дурсгал илэрч байсан билээ. Харин энэхүү дээврийн нөмрөг ваар дээрх шинэ дурсгал нь Уйгур улсын үед холбогдож байгаагаараа онцлогтой болно.

Нэгдүгээр хувилбарын тухайд, бичээснээ “Морин жилийн долоодугаар сарын хоринд бид” гэж буй нь тэд тахилын сүм байгуулсныг тодотгон тэмдэглэжээ хэмээн үзэж болох ба харин бичигч уг бичээсийг бичсэн тул өөртөө хамаатуулж “бичив би” гэж төгсгөсөн байж болох юм.

Тодруулбал бид гэж буй тул, ᠪᠢᠳᠢᠮ (bitdim бичив би) биш, харин ᠪᠢᠳᠢᠮᠢᠵ (bitdimiz бичив бид) гэж нэгдүгээр биеийн олон тоонд хамаатуулан бичих учиртай.

Хоёрдугаар хувилбарын тухайд, äbiz (Эбиз~ Абиз) гэх хүний нэр дурдагдаж байна гэж үзвэл, өмнөх уншлагатай харьцуулахад хэлзүйн хувьд хамгийн зөв, боломжтой хувилбар гарч байна. Өөрөөр хэлбэл, бичээсийн хувьд нэгдүгээрт Морин жилийн долоодугаар сар гэдэг нь уг үйл явдал болсныг илтгэсэн гол өгүүлбэр, харин Эбиз (Абиз) хоринд бичив гэдэг нь бичээс бичсэн тухай тэмдэглэсэн удаах өгүүлбэр болно. ᠪᠢᠳ гэх үгийн эхний “ᠳ” үсэг тэмдэгтийг “ᠳ” хэлбэрээр бичсэн байх бөгөөд уг үсгийн дээрх мэт хувилбар Монголын руни бичгийн дурсгалуудад тохиолддоггүй билээ.

Тахилын байгууламж хийгээд тахилын хавтан үйлдэж хийсэн, хээлж чимэглэсэн тухайд ихэвчлэн ᠪᠢᠳᠢᠮᠢᠵ (bädiztimiz) гэсэн тогтсон үгээр илэрхийлдэг билээ.

Энэхүү дурсгал олдсон газар нь тахилын сүм тул ийнхүү зөвхөн бичээс бичсэн тухайгаа тэмдэглэн үлдээсэн байж болох юм.

Нэг хоёр буюу цөөн хэдэн мөрөөс бүтэх “бага бичгийн дурсгалууд”- д ихэвчлэн он, сар, өдөр огт тэмдэглэгдээгүй тул бичээсийн үсэг тэмдэгт, бичлэгийн хэлбэр, тигээр баримжаалахаас бус чухам тэдгээрийг хэдэн онд үйлдсэн болохыг баттай тогтооход бэрхтэй байдаг билээ.

Тиймээс он, сар, өдөр тодорхой байгаа эл дурсгал түүх, археологийн судалгааны чухал эх хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй.

Зарим үгийн тухайд;

ᠶᠠᠨᠲᠤ (yont~ yunt)- Уг үгийг ᠶᠠᠨᠲᠤ үсгийг ᠶ хэлбэрээр бичсэн нь өмнө Монгол нутаас олдсон руни бичгийн дурсгалуудад тэмдэглэгдэж байгаагүй, бичлэгийн өвөрмөц нэгэн хувилбар болно.

Монгол нутаг дахь түрэгийн үеийн сонгодог дурсгалуудад ᠶᠠᠨᠲᠤ (yont) гэх энэ үг тохиолдохгүй, харин уйгурын үеийн дурсгалуудад буй. Жишээ нь, Моюнчурын гэрэлт хөшөөний баруун талын 9, 10-р мөрөнд “biṅ yunt-мянган адуу” гэсэн хэлбэрээр тохиолдоно.

Түүнчлэн Енисейн бичээсүүдэд, “alti biṅ jontim- миний зургаан мянган адуу” (Тувагийн Уюк Туран (E-3) бичээсийн тавдугаар мөрөн), “biṅ bodraq jont- бэлчиж буй мянган адуу” (Кежээлиг Хову (E-45)-гийн бичээсийн наймдугаар мөр), “üč jüz bodraq jontim- миний бэлчиж буй гурван зуун адуу” (E-55)⁴ гэх зэргээр мөн тохиолдоно.

Дээрх жишээ баримтаас үзэхэд, Монгол болон Енисейн руни бичгийн дурсгалуудад ᠶᠠᠨᠲᠤ (yont) гэх үг “адуу, адуун сүрэг” гэсэн олны утгаар түгээмэл хэрэглэгдэж байжээ гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Тэгвэл сурвалж бичгүүдэд тэмдэглэгдээгүй нь уг үгийг жилийн нэрийн утгаар

⁴ И.В.Кормушин, Тюркские Енисейские Эпитафии (грамматика и текстология), Москва, 2008, стр.92-94; 134-136;146.

төдий л хэрэглэдэггүй байсантай холбоотой юу, эсвэл “морь” жил руни бичгийн дурсгалуудад тохиолдохгүй байгаатай холбоотой юу гэсэн асуулт зүй ёсоор гарна.

Үүнийг нягтлахын тулд сурвалжийн мэдээ баримтыг шүүн үзэх хэрэгтэй болно. Тэгэхээр эртний түрэг хэлбичгийн залгамж болох уйгур хэл бичгээрх гэрээ, хууль цаазын дурсгалд жилийн нэрээр буюу “*yunt yil-morin жыл*” (Sa08; Lo20) хэмээн⁵, түүнчлэн Кашгарын Махмутын толь бичигт арван хоёр жилийг

سِیْلِ یِ نَاغْ جِ سِ sīčyan yīlī

دَوَا یِ یِ ud yīlī

پارسِ یِ سِ رِبِ pars yīlī

تَاوْشْ یِ نَاغْ شِ قِ تِ tawšyan yīlī

نِکِ یِ لِ كِ انِ nek yīlī

یِلانِ یِ نالِ یِ yilan yīlī

یوندِ یِ دُنِ یِ yund yīlī

قوِ یِ یِ qoy yīlī

بِجِ یِ نِ جِ بِ bičin yīlī

تاقِ یِ وِ غِ اقِ تِ taqayū yīlī

یتِ یِ یِ it yīlī

سِیْلِ یِ دُنِ یِ tonpuz yīlī”⁶ хэмээн жагсааны дотор “морин жыл”-ийг “*یِلِ یِ دُنِ یِ yund yīlī*” гэжээ.

Сурвалж, толь бичгийн дээрх баримт нь эрт цагаас түрэг угсаатан “морь жил” буюу “морин жил”-ийг 𐰽𐰺𐰍 (yont~ yunt) гэж нэрэлдэг байсныг баталж байна. Бичээст дурдагдаж буй морин жил чухам хэдэн он болохыг тогтоох нь хамгаас чухал бөгөөд археологичид уг дурсгалыг уйгур нарт холбогдоно гэж буй тул бид энэ үед хамаарах “морин жил”-ийг онцлон авч үзлээ. 700-гаад оноос хойш тохиож байсан “морь жил”-ийг дурдвал: 706, 718, 730, 742, 754, 766, 778 он болно.

Уг тахилын сүмийн археологийн зарим олдворын дээжид хийсэн судалгаагаар он цаг нь илүү тодорхой болох буй за.

ᠶᠢᠲᠢᠨᠢᠶᠦ (yitinč), - Уг үгийг ихэвчлэн ᠶᠢᠨᠳᠦ (ytnč) гэж бичдэг тогтсон бичлэгтэй бөгөөд энэ нь Монголын руни бичгийн дурсгалуудад хамаатай болохыг тэмдэглэе. Харин бичээснээ ᠶᠢᠲᠢᠨᠢᠶᠦ (yitinč) хэмээн амилуулан унших 𐰽(i) эгшгийг бичсэн нь энэхүү бичээсийн нэгэн онцлог хэмээн үзэж болно.

Эл дурсгалд “𐰽” үсэг тэмдэгтийг “𐰽” хэлбэрээр бичсэн байх бөгөөд уг үсгийн дээрх мэт хувилбар Монголын руни бичгийн дурсгалуудад тохиолддоггүй билээ.

⁵ ウイグル 文契文約書集成・著者 山田信夫・編者・小田壽典・P. ツィーメ・梅村 坦・森安孝夫・大阪学出版会 (Nobuo Yamada, Sammlung Uigurischer Kontrakte, Band II(Band I-III), Herausgegeben von Juten Oda, Peter Zieme, Hiroshi Umemura, Takao Moriyasu, Osaka University Press), 1993, pp.18; 102

⁶ Divanü Lûgat-it Türk, Tercümesi, Çeviren Besim Atalay, Cilt I, II, II, 4. baský, Ankara, 1998, s. I,346-8; 292-9; II, 153-7; III, 7-15,17; 9-13; 223-25.